



“Оюу Толгой” ХХК-ийн Уул, уурхайн ажилтны УЭХ - ны
Тэргүүлэгчдийн 2023 оны 12 дугаар сарын 05 -ны
16 дугаар тогтооолын хавсралт

ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ, УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДОТООД ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛСАН ДАУГААРТ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл



- 1.1 “Оюу толгой” ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо (цаашид “УЭХ” буюу “Үйлдвэрчний эвлэлийн хороо” гэх) нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн, “Оюу толгой” ХХК-ийн ажилтнуудаас бурдсэн гишүүнчлэлтэй хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор нэгдсэн гишүүдийн бие даасан нэгдэл байна.
- 1.2 Үйлдвэрчний эвлэлийн хороо нь дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ба Улсын бүртгэлт бүртгүүлж гэрчилгээ авна.
- 1.3 Үйлдвэрчний эвлэлийн хороо нь бэлгэ тэмдэг, уриа, туттай байх бөгөөд Тэргүүлэгчдийн Зөвлөлөөс батална.
- 1.4 Үйлдвэрчний эвлэлийн хороо нь үйл ажиллагаандaa тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас ашиглах бөгөөд хэвлэл, цахим хуудас, банкинд харилцах, данс, хадгаламжтай байна.
- 1.5 Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (цаашид МҮЭХ гэх)-ны дүрэм, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбоо (цаашид салбарын УЭ-ийн холбоо гэх)-ны дүрэм болон энэхүү журмыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллаж, ажил олгогчийн ёмне ажилтнуудыг төлөөлөх болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 1.6 Энэхүү дүрэмд хэрэглэсэн дор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.6.1. “УЭХ” гэж “Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороог,
 - 1.6.2. Англи хэлээр “Trade Union Committee of Oyu Tolgoi LLC’s Mining Employees” гэж, товчилсон нэрээр “OTTUC”
 - 1.6.3. “Компани” гэж Оюу Толгой ХХК-ийг;
 - 1.6.4. “УЭХ”-ийн гишүүд” гэж Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад гишүүнээр элссэн “Оюу толгой” ХХК-ний үндсэн ажилтныг;
 - 1.6.5. “Тэргүүлэгчдийн зөвлөл” гэж “Оюу толгой” ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны Бүх гишүүдээс сонгогдсон төлөөллийг;
 - 1.6.6. “Хяналтын зөвлөл” гэж УЭХ-ны Бүх гишүүдээс сонгогдсон нэр бүхий гишүүдийг;
 - 1.6.7. “Ажлын алба” гэж УЭХ-ны өдөр тутмын ажил үүргийг зохион байгуулж, гүйцэтгэх ажилчдыг;

Хоёрдугаар зүйл. Эрхэм зорилго

- 2.1 Үйлдвэрчний эвлэлийн хорооны эрхэм зорилго нь “Оюу толгой” ХХК-тай байгуулсан хамтын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрх, цалин хөлс

болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, амьдралын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн харилцаан дахь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Гуравдугаар зүйл. Зорилтууд

Эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:


- 3.1 ҮЭХ-ны гишүүдийн эрх ашгийг Ажил олгогчтой хэлэлцээр байгуулах болон хэрэгжүүлэх шатанд төлөөлөх, хамтын гэрээ байгуулах, уг гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
- 3.2 Хөдөлмөрийн стандартууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нехцэл шаардлагыг ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд хангуулах, үйлдвэрлэлийн осол гаргуулахгүй байх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах талаар идэвхтэй нөлөөлөх
- 3.3 “Оюу толгой” ХХК-ийн ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, хэлэлцээ хийх, ажил хаях локаут зохион байгуулах зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад салбарын ҮЭ-ийн холбоотой хамтран ажиллах, үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн дэх ардчилсан ололт, амжилтыг бататгах үндсэн дээр үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний хүч чадал, дотоод ардчилал, эв нэгдлийг бэхжүүлэх замаар ҮЭ-ийн эгнээг өргөтгөх
- 3.4 ҮЭХ-ны үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, залуучууд болон нийгмийн цөөнхийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг идэвхжүүлэх
- 3.5 Хүнд суртал, авилга, хээл хахуулийн эсрэг тэмцэх, нийгмийн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах
- 3.6 Хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон ашиг сонирхлыг хамгаалах талаар хуулийн тесэл боловсруулахад тохиолдолд санаачилгатай оролцох, ажилчид, гишүүдээ төлөөлж санал хүргүүлэх
- 3.7 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг хүчтэй болгоход МҮЭХ, салбарын ҮЭ-ийн холбоотой хамтарч болон дангаар нөлөөлж, үйлдвэрчний эвлэлийн үндэсний хэмжээний хяналтыг зохион байгуулахад оролцох
- 3.8 Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах, хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан, ажил хаялт, локаут болон хамтын тэмцлийн бусад ажиллагаг зохион байгуулахад МҮЭХ, салбарын ҮЭ-ийн холбоог татаан оролцуулж, үйлдвэрчний эвлэлийн хамтын тэмцэл, үйл ажиллагааг дэмжих
- 3.9 Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн, хөдөлмөр-нийгмийн асуудлаар бие дааж болон МҮЭХ, салбарын ҮЭ-ийн холбооны хийж буй судалгааны ажилд хамтран оролцох, дэмжлэг үзүүлэх
- 3.10 Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нехцелийг бүрдүүлэх, ҮЭХ-ны санхүүг хууль, дүрэм журмын хүрээнд зөв зарцуулах
- 3.11 Хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагад гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлөн хамгаалах
- 3.12 Хөдөлмөрлөх эрхийг хохироосон захиргааны шийдвэрийг түдгэлзүүлэн зогсоохыг болон өөрчлөх, хүчингүй болгох, гэрээг цуцлахыг шаардах;
- 3.13 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалахтай холбогдсон аливаа асуудлаар гишүүд, ажилтны санаа, бодол, эрэлт хэрэгцээг судлан захиргаанд шаардлага тавих, мэдэгдэл гаргах, зохих байгууллагад төлөөлөх;
- 3.14 Гишүүд, ажилтныхаа зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоолгооор шүүхэд төлөөлөх, нэхэмжлэл гаргах;
- 3.15 Хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон аливаа асуудлыг хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэхийг санал болгох буюу гишүүдээрээ бие даан хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 3.16 Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдээллийг захиргаанаас гаргуулан авах;

- 3.17 Олон улсын болон гадаад улсын үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, Олон улсын Хөдөлмөрчдийн байгууллага, сангууд болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах

Дөрөвдүгээр зүйл. Зарчим

Үйлдвэрчний эвлэлийн хороо нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:

- 4.1 МҮЭХ-ны дүрэм, Салбарын УЭ-ийн холбооны дүрэм, журмуудтай үйл ажиллагаагаа, уялдуулж журмын хүрээнд ажиллана.
- 4.2 Хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийг эрхэмлэх, аливаа нам, улс төр, шашны үйл ажиллагаанаас ангид байх, ажил олгогч болон бусад этгээдүүдээс хараат бус, бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4.3 Бүхий л үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулна. Албан ёсны мэдээллийн суваг нь www.ottu.mn/үйлдвэрчний_эвлэл/ цахим хуудас байна.
- 4.4 Бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх, тэднийг төлөөлөх бөгөөд үйл ажиллагаандаа нийт гишүүдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэнэ.
- 4.5 Фөрийгээ удирдан санхүүжүүлнэ.
- 4.6 Засгийн газар, ажил олгогч, бусад байгууллагуудтай нийгмийн түншлэлийн зарчмыг удирдлага болгон хамтран ажиллана.
- 4.7 Үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультинууд нь эв санааны нэгдэл, ёс зүйг эрхэмлэн дээдэлж хамтран ажиллана.
- 4.8 Үйлдвэрчний эвлэлийн бүтцийн нэгжүүд шийдвэр гаргах үйл ажиллагаандаа хамтын удирдлагын зарчмыг баримталж, олонхын саналаар шийдвэр гаргах ба энэхүү шийдвэрийг бүх түвшинд дагаж мөрдөж ажиллана.
- 4.9 Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчилж ажиллана.
- 4.10 Хүйсийн тэгш байдлыг хангах зарчим



Тавдугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

- 5.1. Журмын үйлчлэх хүрээ нь "Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо"-ны гишүүдэд үйлчилнэ.

Зургаадугаар зүйл. Журмын дагаж мөрдөх

- 6.1. "Оюу толгой" ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүд дагаж мөрдөнө.

Долоодугаар зүйл. Журмын хэл

- 7.1. Энэхүү журмыг Монгол болон Англи хэл дээр үйлдэх бөгөөд аль аль хэл дээрх бичвэрүүдийг тайлбарлах талаар эрх зүйн маргаан гарвал Монгол хэл дээрх эхийг баримтална.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ БҮТЭЦ,
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Наймдугаар зүйл. УЭХ-ны бүтэц, удирдлага зохион байгуулалт

- 8.1. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, дарга, түүний ажлын алба гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулна.

Есдүгээр зүйл. УЭХ-ны гишүүний, эрх, үүрэг

- 9.1. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь сайн дурын үндсэн дээр хүсэлт гарган, эвлэлдэн нэгдсэн “Оюу толгой” ХХК-ийн ажилтан бүр гишүүн /цаашид “гишүүн” гэх/ нь байна.

- 9.2. Гишүүний бүртгэлийг УЭХ-ны ажлын алба хариуцах ба шийдвэрийг үндэслэн бүртгэл хийнэ.

- 9.3. Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж, татвар төлснөөр гишүүний эрх, үүрэг үүснэ.

- 9.4. УЭХ-ны гишүүн нь өөр УЭХ-ны гишүүний давхцалгүй байна..

- 9.5. Үйлдвэрчний Эвлэлийн хорооны гишүүн нь дараах эрхийг эдэлнэ.

9.5.1. УЭХ-оор дамжуулан хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар эрх ашгаа хуулийн дагуу хамгаалуулах

9.5.2. Хамтын гэрээгээр тохирсон хөнгөлөлт, хангамж, урамшууллыг эдлэх

9.5.3. УЭХ-ны үйл ажиллагаа, үндсэн чиглэл, бодлого боловсруулахад шууд болон төлөөллөөр дамжуулан үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, шаардлага тавих

9.5.4. Хамтын гэрээний нэмэлт өөрчлөлт, УЭХ-ны дүрэмд санал өгөх

9.5.5. УЭХ-ны Дарга, Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх, сонгогдох, татгалзах, төлөөллөөрөө дамжуулан тэдгээрийн сонгох

9.5.6. МҮЭХолбоо болон салбарын УЭ холбоо-ны хамтын ажиллагаа бүхий сургалт, үйлчилгээ, амралт сувиллаар тухайн жилд хөнгөлөлттэй үйлчлүүлэх

9.5.7. МҮЭХ, салбарын УЭ-ийн Холбооноос, тус УЭХ- нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хууль эрх зүйн зөвлөгөө авах

9.5.8. УЭХ-ны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдахгүй байна гэж үзвэл үндэслэл бүхий гомдолыг зохих этгээдэд гаргах, шийдвэрлүүлэх

9.5.9. Шууд болон төлөөллөөр дамжуулан УЭХ-ны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцах

9.5.10. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх

- 9.6. Үйлдвэрчний Эвлэлийн хорооны гишүүн дараах үүрэгтэй

9.6.1. Хууль ёсыг дээдлэн сахиж, МҮЭХ, салбарын УЭХолбооны дүрэм, тус УЭХ-ны дүрэм, ёс зүйн хэм хэмжээг сахин баримтлах

9.6.2. УЭХ-ны гишүүний тогтоосон татварыг төлөх

9.6.3. Үйл ажиллагааны чиг баримтлал, бодлого, шийдвэрийг дэмжин хэрэгжүүлэх, хамт олондоо сурталчлах, УЭХ-ны эгнээг өргөжүүлэхэд оролцох

9.6.4. Ашиг сонирхлоо хамтран хамгаалах, гишүүд хоорондын харилцааг бэхжүүлэх, бие биез хундлэх, нэгдлийг бэхжүүлэх,

9.6.5. УЭХ-нд гомдол, саналыг бичгээр, албан ёсны майл хаягаар гаргана.

9.6.6. УЭХ-оос зохион байгуулж байгаа арга хэмжээ, санал асуулга, хуралд идэвхтэй оролцох, хамрагдах

9.6.7. Журмын хүрээнд тойргийнхоо Тэргүүлэгч гишүүнтэй хамтран ажиллах

9.6.8. УЭХ-ны үйл ажиллагаанд сергеер нөлөөлөхгүй, нэр хүндийг хамгаалах

9.6.9. УЭХ-ны сонгуулт ажилтан, ажлын албаны ажилтнуудын нэр хүндэд халдахгүй байх

9.7. Гишүүнд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- 9.7.1. Өөрт эрх олгогдоогүй асуудлаар ҮЭХ-г төлөөлөх, мэдэгдэл хийх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх
- 9.7.2. Гишүүн нь нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл, дотоод мэдээлэл болон байгууллагын нууцыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр /зурагт, facebook г.м үүгээр хязгаарлагдахгүй/ задруулахгүй байх
- 9.7.3. Үйлдвэрчний эвлэлийн хороог хуваах, тусгаарлах, өөрчлөх, нэгтгэх, нийлүүлэх
- 9.7.4. Улс төрийн болон шашны үйл ажиллагаа эрхлэх, сурталчлах зорилгоор үйл ажиллагаа явуулах
- 9.7.5. Ижил иэртэй байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох

9.8. Дараах тохиолдлуудад гишүүний эрх, үүрэг дуусгавар болно.

- 9.8.1. Өөрийн хүснэгтээр гишүүнээс татгалзах хүснэгтээ гаргасан
- 9.8.2. Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолд

9.9. Өөрийн хүснэгтээр гишүүнээс татгалзсан тохиолдолд дахин элсэх хүснэгтийг 1 жилийн дараа гаргах эрхтэй

9.10. ҮЭХ-ны гишүүнийг доорх үндэслэлээр ҮЭХ-ны гишүүнээс хасах эсэхийг Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар 14 хоногийн дотор шийдвэрлэнэ. Үүнд:

- 9.10.1. ҮЭХ-ны дурэм, ёс зүйн дүрмийг зөрчсөн
- 9.10.2. ҮЭХ-ны эв нэгдэл, нэр хүндэд хохирол учруулсан

Аравдугаар зүйл. Гишүүний хураамж

10.1. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь гишүүдийнхээ татварыг сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогогос сар бүр хураана.

10.2. ҮЭХ-ны гишүүний эрх, үүрэг дуусгавар болсон тохиолдолд өмнө төлсөн татварыг буцаан олгохгүй.

Арав нэгдүгээр зүйл. ҮЭХ-ны бүх гишүүдийн оролцоо

11.1. ҮЭХ-ны бүх гишүүд нь Тэргүүлэгч, болон Хяналтын зөвлөлийг зохих сонгуулиар сонгон, төлөөллийн замаар эрхээ хэрэгжүүлнэ.

11.2. ҮЭХ-ны нийт гишүүдийн олонх /50-аас дээш хувь/ оролцсон тохиолдолд сонгуулийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

11.3. Бүх гишүүдийн дийлэнх олонхын саналаар хэлэлцэн, тогтоол гаргаж асуудлыг шийдвэрлэж болно.

Арван хоёрдугаар зүйл. ҮЭХ-ны үүсгэн байгуулагч, түүний эрх, үүрэг

12.1. Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хувьд холбогдох байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл гаргуулж авах

12.2. ҮЭХ-ны нэр өөрчлөх, хорооны бүтцийн аливаа өөрчлөлт хийх зэрэг зайлшгүй тохиолдолд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс улсын бүртгэлийн байгууллагуудад өөрийн биеэр төлөөлөх, гарын үсэг зурах

12.3. Дүрмийн дагуу сонгогдсон ҮЭХ-ны Даргыг хуулийн этгээдийн хувийн хэрэг дэх мэдээлэлд бүртгүүлэх

12.4. Хууль бус тогтоол шийдвэр, ҮЭХ-ны удирдлагатай холбоотой маргаантай асуудалд хуулийн байгууллагуудын өмнө төлөөлөх

Арван гуравдугаар зүйл. УЭХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөл, тэдгээрийн эрх, үүрэг

- 13.1. УЭХ-ны удирдлагыг бүх гишүүдээс сонгогдсон, тэдгээрийг төлөөлөн шийдвэр гаргах Тэргүүлэгчдийн Зөвлөл хэрэгжүүлнэ.
- 13.2. УЭХ нь 17 Тэргүүлэгч гишүүдтэй байна. Тэргүүлэгч гишүүдийн тоог нийт гишүүдийн тоонд нийцүүлэн өөрчилж болох бөгөөд сондгой тооны бүрэлдэхүүнтэй байна. Сонгуулийн хороо нь тэргүүлэгч гишүүдийн тоог өөрчлөх эрх сонгуулийн хорооны хураар олгогдоно.
- 13.3. Тэргүүлэгчдийн зөвлөл нь шийдвэрээ тогтоол хэлбэрээр гаргана.
- 13.4. Тэргүүлэгчдийн зөвлөл сард хоёр奥斯 доошгүй удаа хуралдана. Хуралдааныг УЭХ-ны дарга зарлан хуралдуулж, зохион байгуулна.
- 13.5. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр奥斯 доошгүй нь оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 13.6. Хурлыг биечлэн болон цахимаар зохион байгуулж болно. Шаардлагатай тохиолдолд зэлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 13.7. Тэргүүлэгчдийн зөвлөл дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 13.7.1. Хамтын гэрээ, хэлэлцээр хийх хэлэлцээнд оролцон гишүүдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалах
 - 13.7.2. Ажил олгогчтой хийх хамтын гэрээнд тусгах асуудлуудыг боловсруулахдаа гишүүдийн саналыг авч, тэдгээрт шинжлэх ухааны үндэстэйгээр тооцоо, судалгаа хийх замаар гэрээний төслийг эцэслэн боловсруулж, ажил олгогчтой хэлэлцээ хийж, батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих
 - 13.7.3. УЭХ-ны тулгамдсан асуудлыг хэлэлцэж, тогтоол гаргах
 - 13.7.4. УЭХ-ны үйл ажиллагааны чиглэл боловсруулах, үнэлэх
 - 13.7.5. Монгол улсын хууль, гэрээ, конвенц болон УЭХ-ны шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон (Санхүү, ёс зүйн, Сонгуулийн, Бусад...)дүрэм, заавар батлах
 - 13.7.6. УЭХ-ны бүтэц, орон тоо, төлөвлөгөө, төсвийг хянаж, батлах
 - 13.7.7. УЭХ-ны даргыг томилох тогтоолыг гаргах, ажлын тайланг дүгнэх, түдгэлзүүлэх, үүрэгт ажлаас нь чөлөөлөх санал гаргах
 - 13.7.8. Ажлын албаны орон тоо, бүтэц зохион байгуулалт, ажилтнуудын цалинг батлах,
 - 13.7.9. УЭХ-ны журмыг зөрчсөн гишүүд, сонгуульт ажилтанд зөвлөгөө, чиглэл өгөх, хариуцлага тооцоо
 - 13.7.10. УЭХ-ны өмч, хөрөнгө санхүүг ашиглахтай холбоотой шийдвэр гаргах
 - 13.7.11. МҮЭ-ийн холбоо, салбарын УЭ-ийн холбооны Бага хурал, Гүйцэтгэх хорооны хуралдаанд оролцож
 - 13.7.12. Хяналтын зөвлөлийн шалгалт хийх хуваарь, УЭХ-ны үйл ажиллагаа явуулахтай холбоотой зардлыг тогтоон батлах
 - 13.7.13. УЭХ-ны гадаад харилцаа, олон улс дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх
 - 13.7.14. Гишүүддээ ажлын тайланг жилд нэгээс доошгүй удаа гарган танилцуулах
 - 13.7.15. УЭХ-ны гишүүдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг гомдол гаргагчид тухай бүр мэдэгдэх
 - 13.7.16. Тэргүүлэгчид жил бүрийн эцэст ажлын үр дүнгээс хамаарч урамшуулал авах
- 13.8. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүний эрхийг доорх тохиолдолд Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурааар түдгэлзүүлнэ:
 - 13.8.1. Энэхүү дүрэм, ёс зүйн дүрэм болон бусад дүрэм, УЭХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөлөөс гаргасан олонхын шийдвэрийг 2 болон түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд

- 13.8.2. УЭХ-ны гишүүдийн хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, хамтын гэрээ, түүнийг байгуулах хэлэлцээ, түүний явцын талаарх мэдээллийг гишүүд, олон нийтэд тараах, задруулах, дарга, тэргүүлэгч гишүүнээс бусад хүмүүст мэдээлэх
- 13.8.3. УЭХ-ны үйл ажиллагааг гутаан доромжлох, олон нийтэд буруу ташаа, серөг мэдээлэл хүргэх
- 13.8.4. Жилийн төлөвлөгөөт хурлын 50 хувиас илүүг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслах
- 13.8.5. Тэргүүлэгч гишүүнийг ажлаа хангалтгүй хийсэн гэж үзэж тухайн тойргийн нийт гишүүдийн гуравны хоёрроос доошгүй нь эгүүлэн татах саналыг батлагдсан загварын өргөдлийн дагуу гаргасан.
- 13.9. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн саналаар үүрэгт ажлаас чөлөөлгөх бол хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд Тэргүүлэгчдийн зөвлөл хүсэлтийг 14-30 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.

Арван дөрөвдүгээр зүйл. УЭХ-ны Тэргүүлэгчийг сонгох

- 14.1. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийг харьяа тойргийн гишүүдээс санал хурааж 4 жилийн хугацаагаар сонгоно. Тойрог болон тойрот хамаарах гишүүдийн тоог сонгуулийн журмаар тогтооно.
- 14.2. Тэргүүлэгч гишүүдийг сонгоходоо гишүүдийн тойрог тус бүрт саналыг хураах бөгөөд санал хураалтад оролцсон гишүүдийн олонхийн/50-аас дээш хувийн/ оролцсон сонгуульд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Тэргүүлэгчээр сонгогдсонд тооцно.
- 14.3. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн сонгуулийг хэсэгчлэн зохион байгуулж болох ба хэсэгчлэн зохион байгуулах үед УЭХ-ны дүрэм, сонгуулийн журмын хэрэгжилтэд Хяналтын зөвлөл, сонгуулийн хорооны гишүүд хяналт тавьж ажиллана.
- 14.4. Хугацаанаас өмнө сонгуульт ажлаас татгалзсан Тэргүүлэгч гишүүний орон тоонд сонгуулийг зохион байгуулж, дараагийн гишүүнийг дүрмийн 14.2-т заасан журмаар сонгоно.

Арван тавдугаар зүйл. УЭХ-ны Дарга, түүний эрх, үүрэг

- 15.1. УЭХ-ны дарга нь орон тооны ажилтан байна.
- 15.2. УЭХ-ны дарга /цаашид дарга гэх/ нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэн Тэргүүлэгчдийн зөвлөл, бүх гишүүд, хяналтын зөвлөлийн өмнө ажлаа тайлагнаж хариуцна.
- 15.3. УЭХ-ны даргын үүрэгт хугацаа 4 жил байна..
- 15.4. Даргын албан тушаалд хөдөлмөрийн насны зохих шаардлагыг хангасан этгээдийг сонгож ажиллуулна.
- 15.5. Дарга нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 15.5.1. УЭХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулна.
- 15.5.2. УЭХ-г гадаад, дотоодод төлөөлнэ.
- 15.5.3. Ажлын албаны орон тоог батлуулж, ажилчидтай хөдөлмөрийн гэрээг хуулийн хүрээнд байгуулж, ажилтнуудыг томилж, чөлөөлөх
- 15.5.4. Ажлын жилийн болон улирлын төлөвлөгөө, холбогдох төсвийг гарган Тэргүүлэгчдийн зөвлөлд танилцуулан батлуулах, гүйцэтгэх
- 15.5.5. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гарган Тэргүүлэгчдийн зөвлөлд танилцуулах
- 15.5.6. Үр нөлөөтэй, тасралтгүй ажиллах нехцөлийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй.

- 15.5.7. Ажил олгогчтой хийх уулзалтад тогтмол оролцох, Хамтын гэрээ байгуулах хэлэлцээнд ажлын хэсгийг ахлан, Тэргүүлэгчдийн зөвлөлийн өгсөн удирдамж, чиглэлийн дагуу оролцох
- 15.5.8. Хөдөлмөрийн тухай хууль, УЭХ-ны дүрэм, хөдөлмөрийн гэрээ болон Ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ чин шударгаар биселүүлэх,
- 15.5.9. Компанийн болон аливаа улс төр, төрийн захиргааны байгууллага, албан тушаалтинаас хараат бус байж, зөвхөн гишүүд ажилчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах
- 15.5.10. Хөдөлмөрийн гэрээгээр тохирсон цалин хэлс, хангамжийг эдлэх

Арван зургаадугаар зүйл. УЭХ-ны Даргыг сонгох, чөлөөлөх

- 16.1. УЭХ-ны даргыг бүх гишүүдийн хурлаар сонгоно.
- 16.1.1. Бүх гишүүдийн хурлыг төлөөллийн зарчмаар зохион байгуулна.
- 16.1.2. Хурлыг тойрог бүрээс сонгогдсон мандат бүхий гишүүд бүрдүүлнэ.
- 16.1.3. Мандаттай нийт төлөөлөгчдийн 50.1-ээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг даргаар сонгоно.
- 16.1.4. Бүх гишүүдийн хурлын ирц 51 хувиас дээш байж хүчин төгөлдөр болно.
- 16.1.5. Тэргүүлэгч гишүүн нь мандаттай төлөөлөгчид багтана.
- 16.2. Сонгуулийн журмын дагуу УЭХ-ны даргын сонгуулийг зохион байгуулна.
- 16.3. УЭХ-ны даргыг бүх гишүүдийн хурлаар үүрэгт ажлаас нь чөлөөлнэ.
- 16.4. УЭХ-ны дүрэм, ёс зүйн дүрэм, санхүүгийн дүрэм, бусад журмыг зөрчсөн тохиолдолд уг асуудлыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар оруулж, олонхын саналаар даргыг үүрэгт ажлаас нь түдгэлзүүлж, түр орлон гүйцэтгэгчийг томилж, чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 16.5. Даргыг 16.1 заалтын дагуу хурлыг зохион байгуулж үүрэгт ажлаас нь чөлөөлне.

Арван долдугаар зүйл. УЭХ-ны Ажлын алба

- 17.1. УЭХ нь ажлын албатай байна.
- 17.2. УЭХ-ны орон тооны ажлын албаны гишүүдтэй Дарга Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллана.
- 17.3. Орон тооны ажлын албыг удирдлагаар хангаж, өдөр тутмын гүйцэтгэлийг дарга хариуцах ба ажлын алба нь дор дурдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 17.3.1. УЭХ-ны бүх гишүүдийн бүртгэлийг хариуцаж, гишүүдийн татвар төлөлтөд хяналт тавих
- 17.3.2. УЭХ-ны Мэдээлэл, бичиг баримт, архив хөтлөлтийг журмын дагуу үйлдэх, тамга, тэмдгийг хууль, журмын дагуу хэрэглэх
- 17.3.3. Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөлийн хэлэлцэх асуудлаар судалгаа, мэдээлэл гарган өгөх, хэлэлцэх асуудлын тогтоолын төслийг бэлтгэх
- 17.3.4. Тэргүүлэгчдийн зөвлөл, УЭХ-ны дарга болон Хяналтын зөвлөлийн аливаа хурал уулзалтуудын тэмдэглэл хетлөн, архивлах
- 17.3.5. Бүх гишүүдийн хурал, уулзалт, гишүүдэд чиглэсэн арга хэмжээний үйл явцыг баримтжуулж, хурлын тэмдэглэл хетлэх
- 17.3.6. УЭХ-ны бүх үйл ажиллагааг Хяналтын зөвлөлд ил тод мэдээлж байх.
- 17.3.7. Үйл ажиллагаандаа УЭХ-ны дүрэм, ёс зүйн дүрмийг чанд мөрдөх
- 17.3.8. УЭХ-ны ажлын албаны орон тооны ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг дараах тохиолдолд дарга дуусгавар болгоно. Үүнд:
- 17.3.8.1 Хөдөлмөрийн тухай хууль, тус байгууллагын дотоод дүрэм, хөдөлмөрийн гэрээг зөрчсөн

- 17.3.8.2 Тэргүүлэгчдийн Зөвлөлийн гишүүдийн олонх нь үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл бүхий санал гаргаж, түүнийг зөвшөөрсөн тохиолдолд хөдөлмөрийн хуулийн дагуу,
- 17.3.9. ҮЭХ-ны өмч херенгө, нэр хүндийн эсрэг ямар нэгэн санаатай болон санамсаргүй хийсэн, хохирол учруулсан бол Монгол улсын холбогдох хууль тогтоомж, өөрийн, дүрэм, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу

Арван наймдугаар зүйл. ҮЭХ-ны Хяналтын зөвлөл

- 18.1. ҮЭХ-ны дотоод хяналтыг аливаа байгууллага, албан тушаалтан, хувь хүний ашиг сонирхлоос ангид, ёс зүйн журмыг чандлан баримталж, Хяналтын хороо хэрэгжүүлэх бөгөөд нийт гишүүдээс сонгогдоно.
- 18.2. Хяналтын хороо 5 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны бус байна. Хяналтын хорооны гишүүдийг 4 жилийн хугацаатай сонгоно.
- 18.3. Хяналтын хорооны даргыг Хяналтын хорооны гишүүд нууцаар санал хурааж сонгоно.
- 18.3.1. Хяналтын хорооны шийдвэр тогтоол байх бөгөөд дарга, гишүүд гарын үсэг зурж, ҮЭХ-ны тэмдэг дарж баталгаажуулна.
- 18.3.2. Хяналтыг зохион байгуулахдаа гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь оролцсон байна.
- 18.4. Тэргүүлэгчдийн зөвлөл, нийт гишүүдэд хяналт шалгалтын тухайд тайлан гарган танилцуулах бөгөөд хяналт шалгалтын дун, асуудалд авах арга хэмжээний тухай саналаа 14 хоногийн дотор Тэргүүлэгчдийн зөвлөлд танилцуулна.
- 18.5. Хяналтын хороо нь дараах эрх, үргийг хэрэгжүүлнэ. Үндл:
- 18.5.1. ҮЭХ-ны дүрмийн хүрээнд, Тэргүүлэгчдийн Зөвлөлийн шийдвэр, тогтоол, түүний хэрэгжилтийг хянах
- 18.5.2. Санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих
- 18.5.3. ҮЭХ-ны нийт гишүүдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн дагуу ажиллана.
- 18.5.4. Журмаар зохицуулагдсан үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар ажлын алба болон холбогдох байгууллага хүмүүсээс мэдээлэл гаргуулж авах, баримт бичигт үзлэг хийх
- 18.6. Ажлын албанад жилд нэгээс доошгүй удаа хяналтыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хяналтыг хийж болно.
- 18.7. ҮЭ-ийн сонгуульт ажилтны ёс зүйн асуудлыг шийдвэрлүүлэхээр асуудал оруулж болно.
- 18.8. Хяналтын зөвлөлийн гишүүд нь жил бүрийн эцэст ажлын үр дүнгээс хамаарч урамшуулал авах

Арван есдүгээр зүйл. ҮЭХ-ны Хяналтын зөвлөлийн гишүүний сонгох

- 19.1. Хяналтын зөвлөлийн гишүүдийг нийт гишүүдээс санал хураалтаар сонгох бөгөөд санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын 50-ас дээш хувийн/ санал авсан нэр дэвшигчийг Хяналтын хорооны гишүүнд сонгогдсон тооцож, Тэргүүлэгчдийн зөвлөлөөс батална.
- 19.2. Хугацаанаас өмнө татгалзсан Хяналтын зөвлөлийн гишүүний орон тоонд сонгуулийг зохион байгуулж, дараагийн гишүүнийг дүрмийн 19.1-д заасан журмаар сонгоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ҮЭХ-НЫ ХЯНАЛТ, АУДИТ

Хорь дугаар зүйл. Хяналт, аудит

- 20.1. ҮЭХ нь "Монгол Улсын Аудитын тухай хууль"-д заасны дагуу санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар баталгаажуулна.
- 20.2. ҮЭХ хорооны Тэргүүлэгчдийн зөвлөл аудитын тайлан гаргуулах шийдвэрийг гаргаж, хяналт тавьж ажиллана.
- 20.3. ҮЭХ-ны жил бүрийн санхүүгийн тайланг баталгаажуулсан хөндлөнгийн аудитын байгууллагын тайланг Тэргүүлэгчдийн хуралд танилцаж, дарга, ажлын албанд үүрэг чиглэл өгч ажиллана.
- 20.4. ҮЭХ-ны үйл ажиллагаанд хяналтын зөвлөл энэхүү дүрэмд заасны дагуу хяналт тавьж ажиллана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ҮЭХ-НЫ САНХҮҮ, ӨМЧ ХӨРӨНГӨ, АРХИВ

Хорин нэгдүгээр зүйл. ҮЭХ-ны санхүү, архив

- 21.1. ҮЭХ нь гишүүнчлэлийн татвараар санхүүжинэ.
- 21.2. ҮЭХ жилийн төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг дарга, ажлын алба нь Тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд жил бүр танилцуулан батлуулж, санхүүгийн хөрөнгийг Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаас баталсан жилийн төсвийн дагуу Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тогтоол, шийдвэрийн дагуу захиран зарцуулж, тайлагнаж, ил тод байдлыг хангана.
- 21.3. ҮЭХ нь банкннд харилцах данс нэг байх бөгөөд, гүйлгээ хийх карттай байна. Татварын тухай хууль тогтоомж, олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэл хөтөлнө.
- 21.4. ҮЭХ-ны санхүүгийн удирдлагыг гэрээт санхүүгийн байгууллага доорх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 21.4.1. Санхүүгийн журмын дагуу зөвхөн Тэргүүлэгчдийн зөвлөлийн тогтоол, холбогдох санхүүгийн баримтуудыг үндэслэн банкны гүйлгээг хийх,
 - 21.4.2. Тэргүүлэгчдийн зөвлөл болон Хяналтын зөвлөлд улирал тутам, мөн шаардлагатай үед санхүүгийн тайлан гаргаж танилцуулах, мэдээлэх ажлыг хариуцах,
 - 21.4.3. ҮЭХ-ны санхүүгийн тайлан баланс, татвар төлөлтийн мэдээллийг тухай бүрт гарган, тооцоолж, харьяа төрийн байгууллагуудад холбогдох тайлан, мэдээг хугацаанд нь тушаах,
 - 21.4.4. ҮЭХ-ны бүх үйл ажиллагааг Хяналтын зөвлөлд ил тод мэдээлж байх,
- 21.5. Төр, улс төрийн болон бусад байгууллага, ажил олгогч ҮЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.
- 21.6. ҮЭХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, дарга, ажлын алба нь энэ дүрэм, ёс зүйн журмыг чанд мөрдөж, гишүүдийн татварын хураамжийг захиран зарцуулж, тайлагнана.
- 21.7. ҮЭХ нь аливаа ашиг хуваарилах, аж ахуйн нэгж, байгууллагад зээл олгох, хандив өгөх, бусад этгээдэд хөрөнгийн баталгаа гаргах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 21.8. ҮЭХ нь өөрийн баримт, бичигт тусгайлсан архивтай байж, архивын журмыг дагаж мөрдөж ажиллана.

Хорин хоёрдугаар зүйл. ҮЭХ-ны өмч, хөрөнгө, зарцуулалт

- 22.1. ҮЭХ-ны өмч хөрөнгө нь гишүүдийн татвараас бүрдсэн, өмчлөдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эдийн болон эдийн бус хөрөнгөтэй байна. Хөрөнгийг ҮЭХ-ны үйл ажиллагаанд зарцуулна.
- 22.3. ҮЭХ-ны санхүү, өмч хөрөнгийг доорх чиглэлд Тэргүүлэгчдийн зөвлөл шийдвэр гаргаж зарцуулна.
- 22.3.1. Гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах,
- 22.3.2. Гишүүдийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх сургалт,
- 22.3.3. Гадаад болон дотоодын "Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг"-ийн үйлчилгээ авах,
- 22.3.4. Гишүүдийг идэвхжүүлэх, гишүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлийн бүх арга хэмжээг зохион байгуулах,
- 22.3.5. ҮЭХ-ны үйл ажиллагааг сурталчлах зорилготой гадаад, дотоод PR арга хэмжээ
- 22.3.6. Үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн гишүүнд 1 удаа хуулийн болон өмгөөллийн үйлчилгээнд нь дэмжлэг үзүүлэх /Тогтоолоор/
- 22.3.7. ҮЭХ-ны үндсэн эрхлэх үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулна.
- 22.4. ҮЭХ нь аливаа ивээн тэтгэлэг, хандив, тусламж өгөхийг хориглоно.
- 22.5. ҮЭХ-ны өмч хөрөнгө нь халдашгүй байна. Бүх гишүүдэд хөрөнгийг зарцуулалтын талаар мэдээлнэ.
- 22.6. ҮЭХ нь өөрийн өмчлөлд байгаа үл хөдлөх болон бусад хөрөнгийн бүртгэл хөтөлнө.
- 22.7. ҮЭХ-ны өмч хөрөнгийг ашиглаж, шамшигдуулсан, үрэгдүүлсэн, завшсан, залиссан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн этгээдэд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг нэхэмжлэн арилгуулна. Шаардлагатай бол шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛ ОРУУЛАХ

Хорин гуравдугаар зүйл. ҮЭХ-ны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

- 23.1. ҮЭХ-ны журманд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг бүх гишүүдийн 1/2, Тэргүүлэгчдийн 2/3 нь гаргасан тохиолдолд гаргасан саналыг бүх гишүүдэд ҮЭХ-ны Дарга, ажлын алба танилцуулна.
- 23.2. Журмын өөрчлөлтийн танилцуулга хийгдсэний дараагаар Тэргүүлэгчдийн зөвлөл тогтоол гарган журмыг батална.
- 23.3. ҮЭХ-ны дүрэмд нэмэлт, хасалт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга оруулбал тухайн зүйл заалтад нь тэмдэглэгээ хийж, өөрчлөлт оруулсан хуралдааны дугаар, огноог хашилгад тэмдэглэж, Шинээр нэмэгдсэн зүйл заалтад тухайн бүлэг зүйл заалтын дарааллын дагуу дугаар өгне.
- 23.4 ҮЭХ-ны дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхийн газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр хучин төгөлдөр болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ҮЭХ-Г ТАТАН БУУЛГАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ

Хорин дөрөвдүгээр зүйл. ҮЭХ-г татан буулгах

- 24.1. ҮЭХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Бүх гишүүдийн үнэмлэхүй олонхи дэмжсэн санал гаргасан тохиолдолд Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 24.2. ҮЭХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Бүх гишүүдийн үнэмлэхүй олонхи санаалаар дэмжигдсэн бол тогтоол гаргаж өөрчлөн байгуулах талаар эсвэл, татан буулгах шийдвэр гаргана.
- 24.3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид зааснаар бүх тооцоог хийж, зээл, зээлийн хүүгийн төлбөр, байгууллагуудын өр, авлагыг барагдуулсны дараа үлдсэн өмч хөрөнгийг татан буулгах Бүх гишүүдийн хурал шийдвэрлэсний дагуу зарцуулна.
- 24.4. ҮЭХ-г өөрчлен зохион байгуулсан тохиолдолд залгамжилсан байгууллага нь түүний өмч хөрөнгийг өмчилне.

АРАВДУГААР БҮЛЭГ. ҮЭХ-НЫ ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Хорин тавдугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 25.1. Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

---00---